



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН  
САЙДЫН ТУШААЛ

2019 оны 05 сарын 14 өдөр

Дугаар А/292

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Бага, дунд боловсролын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэг, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.1, 14.3.2, 15.1.1 дэх заалтыг үндэслэн, Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2 3.2.13, 3.2.14 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран сургах журам”-ыг нэгдүгээр, “Хүүхдийн хөгжлийг дэмжих танхим”-д байвал зохих хэрэглэгдэхүүн, туслах хэрэгслийн жагсаалтыг хоёрдугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Журмыг 2019-2020 оны хичээлийн жилээс эхлэн мөрдсүгэй

3. Журмыг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Ерөнхий боловсролын бодлогын газар /Г.Ням-Очир/, журмыг хэрэгжүүлэхэд шаардагдах сургуулийн дэд бүтцэд орох өөрчлөлтийн судалгаа хийн, санал боловсруулж 2019 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор танилцуулахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар /С.Нансалмаа/-т тус тус үүрэг болгосугай.

4. Журмыг хэрэгжүүлэх бэлтгэл хангах, сургуулийн орчин нөхцөлийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцах боломжоор тохижуулах, харьяа нутаг дэвсгэрийн сургуулийн насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн судалгаа гаргах ажлыг энэ оны 8 дугаар сард багтаан хэрэгжүүлэхийг аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар, нийслэлийн Боловсролын газрын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

САЙД



Ё.БААТАРБИЛЭГ

300965

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын  
сайдын 2018 оны 05 дугаар сарын 14-ны  
өдрийн А/292 дугаар тушаалын  
нэгдүгээр хавсралт

## ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙГ ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД ТЭГШ ХАМРАН СУРГАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд /цаашид “хүүхэд” гэх/-ийг ерөнхий боловсролын тусгай сургуулиас бусад хэв шинж бүхий сургууль /цаашид “сургууль” гэх/-д сургахтай холбогдох харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Энэхүү журмыг хэрэгжүүлэхэд Нэгдсэн Үндэстний байгууллагаас баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц”, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай, Боловсролын тухай, Бага, дунд боловсролын тухай, Хүүхдийн эрхийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох эрхийг хангах талаар тусгасан хэм хэмжээг удирдлага болгоно.

### Хоёр. Баримтлах зарчим

2.1. Хүүхдийг сургуульд тэгш хамран сургах үйл ажиллагаанд дараах зарчим баримтална:

2.1.1. Хүүхдийн сурч боловсрох, хөгжих эрхийг хүндэтгэх;

2.1.2. Хүүхдийн онцлог, хэрэгцээнд нийцсэн чанартай боловсрол эзэмшүүлэх;

2.1.3. Хүүхдийн ялгаатай байдлыг хүндэтгэх, өөртөө итгэх итгэлийг хөгжүүлж бусадтай харилцах, хамтран ажиллах, нийгмийн амьдралд идэвхтэй оролцох оролцоог дэмжих;

2.1.4. Аливаа ялгаварлан гадуурхалтаас ангид байх.

### Гурав. Удирдлага, зохион байгуулалт

3.1. Сургууль нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 14.3.1 дэх заалтад заасны дагуу хамран сургах тойрогт хамаарах хүүхдийг сургуульд бүрэн хамруулах ажлыг хариуцна.

3.2. Сургууль нь нийгмийн хамгаалал, боловсрол, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хамтран баталсан зааврын<sup>1</sup> дагуу сум, хорооны “Сургуульд хамрагдалтыг дэмжих зөвлөл”-тэй хамтран ажиллана.

<sup>1</sup> Хөдөлмөр нийгмийн хамгаалал, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спорт, Эрүүл мэндийн сайдын хамтарсан “Заавар, маягт батлах тухай” 2018 оны А/304, А/699, А/460 тоот тушаал